

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ 7 САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 08 дүгээр сарын 10

Мандалговь хот

## **Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхдээ тайлан мэдээлэл, түүнийг нотолж буй баримтад тулгуурлан хяналт-шинжилгээ үнэлгээг хийсэн бөгөөд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг орон нутагт чанартай, үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүний хэрэгжилт үр дүнгийн талаар аймгийн удирдлагуудыг болоод Засгийн газрын Хэрэг эрхлэх газрыг үнэн зөв мэдээллээр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ”-д заасан үнэлгээ хийх аргачлалын дагуу гүйцэтгэлээ.

Аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалтыг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дүнд явцын хяналт шинжилгээг тусгай удирдамж гарган аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагт зохион байгуулан зөвлөн тусалж ажиллалаа.

## **Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр 8 сарын байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан /[unelgee.gov.mn/](http://unelgee.gov.mn/)-д байршуулсан 87 шийдвэр: Улсын их хурлын тогтоол -70, Засгийн газрын тогтоол-58, Засгийн газрын албан даалгавар-1 нийт 129 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж 85.42 хувиар үнэлэв.

Хэрэгжилтийн үнэлгээний үе шат тус бүрээр нь авч үзвэл:

- Бүрэн хэрэгжсэн 74 заалт нь нийт заалтын 63 хувийг
- Хэрэгжих шатандаа байгаа 34 заалт нь 29 хувийг
- Хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн 10 заалт нь 0,8 хувийг
- Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 11 заалт 0,9 хувийг эзэлж байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалт болон хэрэгжилтийн явцыг Dundgovi.gov.mn сайт, төрийн байгууллагын цахим программ болох erp.e-mongolia.mn программын файлын сан хэсэгт байршуулан мэдээллээр ханган ажиллаж байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 87.86 хувьтай буюу үр дүнтэй хэрэгжсэн байна. Засгийн газрын албан даалгаврын дундаж 70 хувийн хэрэгжилттэй байгаа нь зохион байгуулалтаас шалтгаалан хэрэгжих шатандаа байна.

### **Гурав. Дүгнэлт**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тусгай удирдамж, шалгуур үзүүлэлтийг урьдчилан гаргаж холбогдох газруудад хүргүүлэн, хяналт-шинжилгээний явцад болон дууссаны дараа ажил сайжруулах чиглэлээр тайлан, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох газруудад хүргүүлж хэрэгжилтийн явцад хяналт тавьж заавар, зөвлөмж нэгдсэн удирдлагаар хангаж ажилласны үр дүнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 85,42 хувьтай хэрэгжсэн байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад шийдвэрийн 18 заалтыг эрчимжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд энэ чиглэлээр холбогдох агентлагуудад чиглэл өгч ажиллах нь зүйтэй.

Цаашид үр дүнг жилийн эцсийн ажил дүгнэх үзүүлэлтэд тусгай шалгуур үзүүлэлт боловсруулан дүгнэх бөгөөд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн сарын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр хэлтэс, агентлагууд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хэрэгжилт гаргах, хяналт тавих явцад гарч буй хүндрэл нь хугацаа болоогүй буюу нэг удаагийн шинжтэй заалтуудыг сар бүр тооцох боломжгүй байдал үүсгэж байна.

### **Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ / Зөвлөмж /**

Санал:

Хэрэгжилт гаргах, хяналт тавих явцад гарч буй хүндрэл нь хугацаа болоогүй буюу нэг удаагийн шинж агуулсан заалтуудыг сар бүр тооцоход шат шатандаа хүндрэлтэй байдал үүсгэж байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлээд нэг удаагийн шинжтэй, хэрэгжилт тогтмолжсон заалтуудыг нэг бүрчлэн шүүн үзэж хяналтаас хасуулах саналыг дээд газарт хүргүүлж байгаа тул саналыг хүлээн авч шийдвэрлэж өгнө үү.

**ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**